

**“ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АСУУДЛААР ИЛ ТОД
БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 01 дүгээр
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Л.Цог**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ!


Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2013 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар урьдчилан зөвшилцсөн “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2014 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн, уг хуулийн төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Ц.ОЮУНБААТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 01 дүгээр
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын 2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

ГАРЫН ҮСЭГ